

Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулахад тавигдах шаардлага, анхааруулгад тусгах мэдээлэл

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмж /цаашид “бичлэгийн төхөөрөмж” гэх/-ийг байршуулахад тавигдах шаардлага, бичлэгийг хадгалах, хамгаалах, мэдээллийн ил тод байдлыг хангах, анхааруулгад тусгах мэдээллийг тодорхойлоход оршино.

1.2.Энэ журам нь Монгол Улсын Үндсэн хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан журам, Монгол Улсын олон улсын гэрээ, ISO/IEC 27001, ISO/IEC 27701 стандартад нийцсэн байна.

1.3.Энэ журмыг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд заасан үндэслэлээр бичлэгийн төхөөрөмж байршуулахад дагаж мөрдөнө.

1.4.“Мэдээллийн эзэн” гэж Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4.1.5-д заасан хүн буюу бичлэгт мэдээлэл нь хадгалагдсан хүнийг ойлгоно.

1.5.“Мэдээлэл хариуцагч” гэж Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4.1.8-д заасан хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг ойлгоно.

Хоёр.Бичлэгийн төхөөрөмж байршуулахад тавигдах шаардлага

2.1.Бичлэгийн төхөөрөмж байршуулахад Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 5.1-д заасан зарчмыг баримтлах бөгөөд дараах нөхцөлийг шалгана:

2.1.1.хүний болон мэдээллийн аюулгүй байдлыг хангах, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор бичлэгийн төхөөрөмж байршуулж байгаа эсэх;

2.1.2.бичлэгийн төхөөрөмж байршуулах хууль, холбогдох журамд заасан үндэслэл байгаа эсэх;

2.1.3.бичлэгийн төхөөрөмж байршуулснаар энэ журмын 2.1.1-д заасан зорилгод хүрч байгаа эсэх;

2.1.4.бичлэгийн төхөөрөмжид хадгалагдсан мэдээлэл /цаашид “мэдээлэл” гэх/-ийн найдвартай, аюулгүй байдлыг хангаж байгаа эсэх.

2.2.Мэдээлэл хариуцагч энэ журмын 2.1-д заасан нөхцөлийг шалгахдаа Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 23.3-т заасан журмыг баримтлан үнэлгээ хийх бөгөөд бичлэгийн төхөөрөмж байршуулах хэрэгцээ, шаардлага байгаа эсэхийг тодорхойлно.

2.3.Мэдээлэл хариуцагч Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 27.3.1-д заасан зорилгоор бичлэгийн төхөөрөмж байршуулахад энэ журмын 2.2-т заасан үнэлгээ хийхгүй бөгөөд доор дурдсан нөхцөлийг бүрдүүлнэ:

2.3.1.бичлэгийн төхөөрөмж байршуулахад оршин суугчдын төлөөллийг оролцуулах, оршин суугчид хяналт тавих, саналаа илэрхийлэх, гомдол, хүсэлт гаргах, шийдвэрлэх боломжийг бүрдүүлэх;

2.3.2.нийтийн зориулалттай орон сууцанд оршин сууж байгаа айл, өрхийн орох, гарах хэсгийг хамруулан бичлэгийн төхөөрөмж байршуулахаас сэргийлэх.

2.4.Мэдээлэл хариуцагч Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 27.3.2-т заасны дагуу ажлын байранд бичлэгийн төхөөрөмж байршуулахад энэ журмын 2.2-т заасан үнэлгээг хийх бөгөөд доор дурдсан нөхцөлийг бүрдүүлнэ:

2.4.1.ажлын байрны дотоод орчинд Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 27.4.1-д заасан /тухайлбал, ажилтны амралтын өрөө, хувцас солих өрөө г.м/-аас бусад байршилд бичлэгийн төхөөрөмж байршуулах;

2.4.2.ажлын байрны гадаад орчинд бичлэгийн төхөөрөмж байршуулахад ажлын байрны орох, гарах хэсгийг хамруулах бөгөөд олон нийтийн зорчих хэсэг /тухайлбал, гудамж, зам, талбай г.м/-ийг хамруулан бичлэгийн төхөөрөмж байршуулахгүй байх;

2.4.3.ажилтанд бичлэгийн төхөөрөмжийн байршил, бичлэгийн төхөөрөмж байршуулах зорилго, үндэслэлийн талаар мэдэгдэж, бичлэгийн төхөөрөмжийн байршлын талаар ажилтнаас санал авах, байршлыг өөрчлөх талаар ажилтны ирүүлсэн гомдол, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх.

2.5.Мэдээлэл хариуцагч энэ журмын 2.4.1-д заасны дагуу ажлын байранд бичлэгийн төхөөрөмжийг хүн ажиглахад хүндрэлтэй, хүний болон мэдээллийн аюулгүй байдал, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдалд эрсдэл учруулж болзошгүй /тухайлбал, ажилтны бэлэн мөнгөтэй харьцаж үйлчилгээ үзүүлэх цэг/ байршилд байршуулна.

2.6.Мэдээлэл хариуцагч бичлэгийн төхөөрөмж байршуулахдаа түүний үйл ажиллагаа (бичлэгийн төхөөрөмж хазайх, дүрсийг томруулах, багасгах үйлдэл г.м), хүчин чадал, чиглүүлэх гол цэг, бичлэгийг хадгалах хугацаа, хувийн мэдээллийг нууцлах үйлдэл зэргийг нарийвчлан судалсан байна.

Гурав.Бичлэгийн төхөөрөмж байршуулсан талаарх мэдээллийн ил тод байдлыг хангах

3.1.Мэдээлэл хариуцагч Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 27.6-д заасны дагуу бичлэгийн төхөөрөмж байршуулсан талаарх анхааруулгыг иргэн саадгүй харах боломжтойгоор байршуулна.

3.2. Анхааруулгад бичлэгийн төхөөрөмж байршуулсан зорилго, мэдээлэл хариуцагчийн нэр, түүнтэй холбоо барих мэдээллийг тусгана.

3.3. Мэдээллийн эзэн энэ журмын 3.2-т заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг мэдээлэл хариуцагчаас шаардах эрхтэй:

- 3.3.1. бичлэгийн төхөөрөмж байршуулсан хууль зүйн үндэслэл;
- 3.3.2. бичлэгийг гуравдагч этгээдэд дамжуулах эсэх, дамжуулахаар бол дамжуулах этгээд;
- 3.3.3. бичлэгийг хадгалах хугацаа;
- 3.3.4. мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаарх авах арга хэмжээ.

3.3. Мэдээлэл хариуцагч энэ журмын 3.3-т заасан хүнд түүний мэдээлэл хүлээж авах боломжтой хэлбэр /утас, имэйл хаяг, нийгмийн сүлжээний хаяг г.м/-ээр холбогдох мэдээллийг хүргүүлнэ.

Дөрөв. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах

4.1. Мэдээлэл хариуцагч мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр доор дурдсан арга хэмжээ авна:

- 4.1.1. мэдээлэлд хандах эрх бүхий этгээдийг томилох;
- 4.1.2. мэдээллийг санаандгүйгээр гэмтээх, устгах, хандах эрх олгогдоогүй этгээд хандах, хууль бусаар мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглахаас хамгаалах арга хэмжээг авах;
- 4.1.3. мэдээлэлд хандах эрхэд хязгаарлалт тогтоох, нууц үг, шифрлэлт хэрэглэх;
- 4.1.4. нийтлэг хэрэглэж заншсан нууц үгийг хэрэглэхээс татгалзах, нууц үгийг бусдад түгээхгүй байх;
- 4.1.5. мэдээллийн хандаж байгаа лог, бүртгэлд тогтмол хяналт тавих;
- 4.1.6. мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, үр дүнгийн талаар тэмдэглэл хөтлөх.

4.2. Мэдээлэл хариуцагч энэ журмын 4.1-д зааснаас бусад мэдээллийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн техникийн болон зохион байгуулалтын арга хэмжээ авч болно.

Тав. Бичлэгийг хадгалах

5.1. Мэдээлэл хариуцагч бичлэгийн төхөөрөмж байршуулсан зорилгод хүрэх хугацаа /Тухайлбал, мэдээлэл хариуцагчийн эд хөрөнгө хулгайд алдагдсан тохиолдолд бичлэгийн төхөөрөмжид хадгалагдсан бичлэгийг Зөрчлийн тухай хууль, эсхүл Эрүүгийн хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаанд буюу уг бичлэгийг нотлох баримт болгон ашиглаж, өөрийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах зорилгод хүрэх хугацаанд хадгалах боломжтой/-г харгалзан бичлэгийг хадгалж болно.

5.2.Энэ журмын 5.1-д заасны дагуу бичлэг хадгалах хугацаа нь бичлэгийн төхөөрөмжийн бичлэг хадгалах хүчин чадлын хугацаагаар хязгаарлагдаж болно.

5.3.Бичлэгийн төхөөрөмжид хадгалагдсан бичлэг устсан тохиолдолд энэ талаар бүртгэл хөтөлж хадгална.

Зургаа.Мэдээллийг ашиглах

6.1.Мэдээлэл хариуцагч мэдээллийг бичлэгийн төхөөрөмж байршуулсан зорилгын дагуу ашиглана. /Тухайлбал, бичлэгийн төхөөрөмжийг хүний болон мэдээллийн аюулгүй байдал, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор ажлын байранд байршуулсан бол бичлэгт хадгалагдсан мэдээллийг ажилтны ирцийг бүртгэх, ажлын гүйцэтгэлийг хянах зорилгоор ашиглахгүй./

Долоо.Мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулах

7.1.Мэдээлэл хариуцагч Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд заасан үндэслэлээр мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулна.

Найм.Мэдээллийн эзэнд мэдээллийн хуулбарыг өгөх

8.1.Мэдээллийн эзэн Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 16.1.8-д заасны дагуу өөрт хамааралтай мэдээллийн хуулбарыг мэдээлэл хариуцагчаас цаасан, эсхүл цахим хэлбэрээр мэдээлэл хариуцагчаас гаргуулан авах эрхтэй.

8.2.Мэдээлэл хариуцагч мэдээллийн эзний хүсэлтийг хүлээн авснаас хойш 1 сарын дотор мэдээллийн хуулбарыг мэдээллийн эзэнд өгөх бөгөөд мэдээллийг хуулбарлах боломжгүй тохиолдолд мэдээллийн эзэнтэй тохиролцсон арга хэрэгслээр мэдээллийг авах боломжийг бүрдүүлнэ.

8.3.Мэдээлэл хариуцагч мэдээллийн эзнээс бичлэг хийгдсэн хугацаа /жил, сар, өдөр, цаг, минут/-г тодруулж болно.

8.4.Мэдээлэл хариуцагч бичлэг хадгалах хугацаа дууссан, бичлэг устсанаас мэдээллийг хуулбарлан өгөх боломжгүй тохиолдолд энэ журмын 8.2-т заасан хугацаанд энэ талаар мэдээллийн эзэнд мэдэгдэнэ.

8.5.Энэ журмын 8.1-д заасан мэдээлэлд гуравдагч этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхөөр бол мэдээлэл хариуцагч Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд заасан журмын дагуу гуравдагч этгээдийн зөвшөөрлийг авна.

Ес.Бусад

9.1.Мэдээлэл хариуцагч бичлэгийн төхөөрөмж байршуулах, түүний аюулгүй байдлыг хангахтай холбоотой чиг үүргийг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 19.1-д заасны дагуу гэрээний үндсэн дээр бусад этгээдээр гүйцэтгүүлж болно.

---o0o---